



## Аароны санваарын чуулгын болон Залуу эмэгтэйчүүдийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлд чиг баримжаа олгох

### БУРХАНААР ДУУДАГДСАН

- Бурханаар дуудагдсан байх гэдэг нь миний хувьд юу гэсэн үг вэ?

---



---

### ҮЙЛЧИЛДЭГ ХҮМҮҮСТЭЭ ТОХИНУУЛ

- Би чуулгынхаа эсвэл ангийнхаа бүх гишүүнтэй хэрхэн сайн танилцаж, тэднийг хайрлах вэ?  
**ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХЫГ ХҮСВЭЛ:** Тойргийн бичиг хэргийн ажилтан чуулгын эсвэл ангийн гишүүдийн жагсаалтыг гаргаж өгөх боломжтой.
- Би Аврагчийн тохинууллын үлгэр жишээг хэрхэн дагах вэ?

---



---

### УДИРДАХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- Би ямар хуралд оролцож мөн оролцохоор төлөвлөж байна вэ?  
Сүмийн тогтмол явагддаг цуглаан болон үйл ажиллагаануудын зэрэгцээ чуулга, ангиудын ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал мөн тойргийн өсвөр үеийнхний зөвлөлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл: (*Ерөнхий гарын авлага: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд үйлчлэх нь*, 10.4.3, 10.4.4, 11.3.4.3, 11.3.4.4, 29.2.9-ийг тус тус үзнэ үү, ChurchofJesusChrist.org).
- Би ямар удирдах үүрэг хариуцлагатай вэ? Надад ямар ямар хэрэгсэл тус болох вэ?  
Хурлаар хэлэлцэх асуудал ("*Ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлын хөтөлбөрийн загвар*")-ыг үзнэ үү), хурал удирдах, ажил даалгах, даалгасан ажлын хэрэгжилтийг шалгах, чуулгын эсвэл ангийн гишүүдийг угтан авч мэндчилэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл (*Ерөнхий гарын авлага*, 4 дүгээр бүлгийг үзнэ үү).

---



---

### ХУРАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ТӨЛӨВЛӨХ

- Бид Ням гаргийн цуглаануудаа хэрхэн урам зориг өгдөг, сүнслэг цуглаан болгох вэ? (*Ирээд, Намайг дага—Аароны санваарын чуулгад болон Залуу эмэгтэйчүүдийн ангид зориулав гарын авлагыг үзнэ үү.*)  
**ИЛҮҮ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:** [ComeFollowMe.ChurchofJesusChrist.org](http://ComeFollowMe.ChurchofJesusChrist.org) руу орж авна уу.
- Бид хэрхэн оролцоо сайтай, үр дүнтэй үйлчлэл, үйл ажиллагаа явуулах вэ? ("*Өсвөр үеийнхний үйлчлэл, үйл ажиллагааны удирдамж*")-ийг үзнэ үү)  
**ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ** [ChildrenandYouth.ChurchofJesusChrist.org](http://ChildrenandYouth.ChurchofJesusChrist.org)-оор орж авна уу.

---



---



# Бишопын зөвлөл, насанд хүрсэн залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдийн удирдагчдад зориулсан мэдээлэл

Бишопын зөвлөл нь шинээр дуудагдсан Аароны санваарын чуулга, Залуу эмэгтэйчүүдийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлүүдэд чиг баримжаа олгох үүрэгтэй. Ерөнхийлөгчийн зөвлөлд удирдамж өгөх нь өсвөр насны удирдагчдад дуудлагаа амжилттай гүйцэтгэхэд нь туслах чухал алхам болдог.

Дараах эх сурвалжууд бишопын зөвлөлөөс шинэ эсвэл одоо байгаа ерөнхийлөгчийн зөвлөлд удирдамж өгөхөд туслах зөвлөмжүүд юм. Эдгээр эх сурвалжийг болон өмнөх асуултуудыг тойргийн өсвөр үеийнхний зөвлөлийн эсвэл бусад тохиолдолд шинэ эсвэл одоо байгаа ерөнхийлөгчийн зөвлөлд чиг баримжаа олгох эсвэл заахдаа товч хэлэлцүүлэг өрнүүлэхэд ашиглаж болно. Бишопын зөвлөлийн удирдамжийн дагуу залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдийн удирдагчид чуулгын эсвэл ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хуралд эдгээр эх сурвалжийг ашиглаж болно.

## ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ЭХ СУРВАЛЖУУД

### Бурханаар дуудагдсан 8-10 МИНУТ

*"Сүмийн үр дүнтэй удирдагч байхын тулд бид Сүмд удирдах гэдэг нь бусдад нэг их зааварлаад байх хэрэг биш бөгөөд энэ нь бусдад туслахдаа Бурханы заавраар удирдуулах хүсэлтэй байх тухай юм гэсэн энэ чухал сургамжаас суралцах ёстой"* (Дийтр Ф.Угдорф, *"Та нарын дундах хамгийн агуу нь,"* Ensign эсвэл 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 64).

- Чуулгын болон ангийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд илчлэлтээр дуудагддаг (Иохан 15:16-г үзнэ үү).
- Аароны санваарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл нь чуулгын ерөнхийлөгч онцгойлон адислагдах үед өгөгдсөн түлхүүрүүдийн дагуу ажилладаг. Залуу эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл нь ерөнхийлөгчийн зөвлөлийн дуудлагад онцгойлон адислагдах үед хүлээн авсан санваарын эрх мэдлийн дагуу ажилладаг (Сургаал ба Гэрээ 42:11; 107:5; Итгэлийн Тунхаг 1:5; *Ерөнхий гарын авлага*, 3.4.1-ийг үзнэ үү).
- Ерөнхийлөгчийн зөвлөл нь Их Эзэн болон Түүний удирдагчдын өмнө үүрэг хүлээдэг (Сургаал ба Гэрээ 104:11-13; Ерөнхий гарын авлага, 4.2.6-г үзнэ үү).
- Ерөнхийлөгчийн зөвлөл нь чуулгад эсвэл ангийн гишүүдэд үлгэр жишээ үзүүлэхээр үйлчилдэг (1 Тимот 4:12; Алма 17:2-3-ыг үзнэ үү).

### Үйлчилдэг хүмүүстээ тохинуул 5-8 МИНУТ

*"Та нар Аврагчийг төлөөлөхөөр дуудагдсан билээ. . . . Таны өргөх гар Түүний гартай адил [болдог]"* (Хэнри Б.Айринг, *"Rise to Your Call,"* Ensign эсвэл Liahona, 2002 оны 11-р сар, 76).

- Үйлчилдэг хүмүүсээ тоол, нэрлэ мөн халамжил (Моронай 6:4-ийг үзнэ үү).
- Бусдад Аврагчийг дагахад нь тусал (Ерөнхий гарын авлага, 4.2.3-ыг үзнэ үү).

### Удирдах үүрэг хариуцлага 5-8 МИНУТ

*"Бие биенээ мөн Сүнсийг сонсох нь Сүмийн зөвлөлийн гайхамшиг юм!"* (М.Рассэлл Баллард, *"Counseling with Our Councils,"* Ensign, 1994 оны 5-р сар, 26).

- Тойргийн өсвөр үеийнхний зөвлөлд оролц (Ерөнхий гарын авлага, 29.2.9-ийг үзнэ үү).
- Чуулгын болон ангийн хурлыг тогтмол явуул (Ерөнхий гарын авлага, 10.4.3, 11.3.4.3-ыг үзнэ үү; "Ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлын хөтөлбөрийн загвар"-ыг үзнэ үү).
- Ажил гүйцэтгэх удирдлагын ур чадвараа хөгжүүл (Ерөнхий гарын авлага, 4.2-ыг үзнэ үү).

### Хурал, үйл ажиллагаануудыг төлөвлө 5-8 МИНУТ

*"Бидний сүмд хийдэг үйл ажиллагаа, хичээл бүр Их Эзэн болон Түүний ариун өргөө рүү заадаг"* (Рассэлл М.Нэлсон, *"Personal Preparation for Temple Blessings,"* Ensign, 2001 оны 5-р сар, 32).

- Үүрэг хариуцлага мэдэж ав (Ерөнхий гарын авлага, 10-11 дүгээр бүлгийг үзнэ үү).
- Сүнсний чиглүүлгийн дагуу төлөвлөж, удирд (Сургаал ба Гэрээ 43:8-9; 88:119; Моронай 6:9).

### НЭМЭЛТ ЗААВАР

Тойргийн өсвөр үеийнхний зөвлөл болон ерөнхийлөгчийн зөвлөлийн ээлжит хурлуудад удирдах ур чадварыг хөгжүүлэх боломжууд байдаг. Уг хичээл зүтгэлд тань дэмжлэг үзүүлэх эх сурвалжуудыг [Чуулгын болон ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн эх сурвалжаас](#) харна уу.